



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№146 /360/

2022.08.18

Цаг үе, үйл явдал

ХОЁРДУГААР ШАТНЫ ТЭМЦЭЭНЭЭС ХОС МӨНГӨ БОЛОН ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас зохион байгуулж буй "Цэргийн ралли-2022" олон улсын тэмцээний хоёрдугаар шат буюу "Нэг бүрийн уралдаан" өчигдөр Бүгд Найрамдах Тува Улсад амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээний Камаз "4x4" ангилалд чиглүүлэгч, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Автотехникийн засварын цехийн агрегат засварын хэсгийн дарга, ашиглалтын инженер ахлах дэслэгч М.Шийрэвноров, жолооч Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн засварын тасгийн дарга, машины дарга ахлах ахлагч Б.Баатархүү нар хүрэл медаль, Урал "4x4" ангилалд чиглүүлэгч Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Инженерийн засварын цехийн дарга ахмад Б.Ариунбаатар, жолооч Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн Тээврийн салааны ахлагч, сургагч ахлагч Х.Ширмэнхоовон нар мөнгөн медаль хүртлээ.

Мөн Урал "6x6" ангилалд чиглүүлэгч Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтын төвийн Замын хөдөлгөөний дүрмийн ахлах багш ахлах дэслэгч Б.Мөнгөнхуяг, жолооч Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн Тээврийн салааны жолооч ахлах ахлагч Б.Алтанхуяг нар мөнгөн медаль хүртэж бахдам амжилтыг үзүүлсэн юм.

Ташрамд дурдахад өнөөдөр тэмцээний 3 дугаар шатанд багийн буудлага (5.45 мм-ийн АКМС-74) болон пулемётын (7.62 мм-ийн ПКТ) буудлагын тэмцээнтэй бол 19-ний өдөр тэмцээний 4 дүгээр шат буюу багийн уралдаанд манай баг тамирчид тус тус өрсөлдөнө.

Ахлах дэслэгч Д.БЯМБАБАЯР



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	☁️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,182.00	3,208.00
EUR 🇪🇺	3,204.00	3,312.00
CNY 🇨🇳	467.60	478.00
RUB 🇷🇺	45.00	57.80
JPY 🇯🇵	23.35	24.06
KRW 🇰🇷	2.30	2.46

ЗУРХАЙ



2022.08.18 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 17

**ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ
САР**

**ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Ус засуулбал:

Эд МАЛ АРВИДНА

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.51-20.01

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал: Ус

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

ОЛОН УЛСЫН "АРМИ-2022" ЦЭРГИЙН НААДМЫН ТЭМЦЭЭНД МОНГОЛ УЛС ОРОЛЦОЖ БАЙНА

Оросын Холбооны Улсын Батлан хамгаалах яамнаас жил бүр зохион байгуулдаг Олон улсын цэргийн наадам "Арми" тэмцээнд "Танкийн биатлон" болон "Армийн соёл, урлаг" төрөлд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид оролцож байна. Тус тэмцээн нь энэ сарын 15-ны өдөр ОХУ-ын нийслэл дэх "Патриот" цэцэрлэгт хүрээлэнд нээлтээ хийсэн юм.

"Олон улсын цэргийн наадам-2022"-г энэ жил тус наадмыг зохион байгуулагч ОХУ-аас гадна Хятад, Вьетнам, Лаос, Казахстан, Иран, Сири, Венесуэл зэрэг нийт 21 орны армийн төлөөлөл оролцож байна. "Армийн соёл, урлаг" төрөлд Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Монгол Улсын музейнүүдийн төлөөлөл болж анх удаа Монгол цэргийн музейгээс "Арван гуравдугаар зууны морьтон дайчид" үзэсгэлэнгээ дэглэн эд өлөг, үзмэрүүдээ толилуулж байна.

Хорь гаруй орны Батлан хамгаалахын музейн байгууллагууд уралдааны эхний шат буюу цахим мэндчилгээ нэрийн хуудсаараа өрсөлдөх нээлттэй санал асуулгыг эхлүүллээ. Олон улсын "Арми-2022" наадмын хүрээнд Монгол цэрэг эрс, эх орончдын баатарлаг гавьяаг үзмэрээрээ толилуулан дэлхийд ахин нэг сануулах үзэсгэлэнгээрээ өрсөлдөж буй юм. Монгол Улсын Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Монгол цэргийн музейг дэмжицгээе.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,129,086

Эдгэрсэн

Нийт: 563,986,818

Нас барсан

Нийт: 6,444,786

ЦЭРГИЙН БАЙР ЗҮЙЧИД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ЧУУЛЛАА



Зэвсэгт хүчний байр зүйн албаны 90 жил, Зэвсэгт хүчний 284 дүгээр анги үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй "Цэргийн байр зүй, геодезийн тусгай батальоны үүсэл хөгжил, ирээдүйн чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал өнөөдөр ҮБХИС-ийн "Сүбээдэй" танхимд боллоо.

Энэхүү хуралд ЗХЖШ-ын Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга бригадын генерал Ц.Гандорж, Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор нарын батлан хамгаалах салбар, Зэвсэгт

хүчний удирдлагын төлөөлөл, ҮБХИС-ийн БХЭШХ, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн байр зүйн офицерууд, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд болох Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Цаг уур орчны шинжилгээний газар, "МонМеп" ХХК, Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн үеийн захирагч нар, ангийн үндсэн салбарын бие бүрэлдэхүүн оролцсон юм.

Зэвсэгт хүчний байр зүйн албаны дарга, Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч хурандаа Б.Даваа-Очир уг Эрдэм шинжилгээний хурлыг нээж,

түүхэн тэмдэглэлт ойнудын мэндийг хүргээд, анхны илтгэлийг хэлэлцүүлээ. Тэрбээр Монголын эртний төрт улсын үеэс өнөөг хүртэл "Газар бол улсын үндэс" гэсэн үндсэн зарчмаар оршин тогтнох явцад Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, НҮБ-аар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх их үйлсэд цэргийн байр зүйчдийн оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн ажил үүрэг тун их буйг онцлон дурдаад цэргийн байр зүй, геодезийн тусгай батальоны үүсэл хөгжлийн талаар илтгэлээ. Хурлаар

эрдэмтэн судлаачид цэргийн байр зүйн олон асуудлын талаар санал бодлоо солилцсон бөгөөд энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь Зэвсэгт хүчний Байр зүйн албаны болон тус ангийн түүхэнд анх удаа ийнхүү өргөн хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог ажээ.

Ташрамд дурдахад, 1932 онд Япон Улс Зүүн хойд Хятадыг эзлэн авч, Манж Го Улсыг байгуулж, БНМАУ-тай 700 км орчим газраар шууд хиллэх болсноос газар нутгийн маргаан эхэлж, Монгол Улсад байр зүйн байгууллага,

алба байгуулах зайлшгүй шаардлага гарсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрийн зураглалын үндсийг бэлтгэх чиглэлээр хийгдсэн геодезийн улсын болон тусгай сүлжээг хөгжүүлэх, цэг тэмдэгтүүдийг тодотгох, шинэчлэх, цэргийн зориулалт бүхий төрөл бүрийн хэмжээсийн цэргийн байр зүйн тусгай зургийг бэлтгэх, геодезийн өгөгдөхүүнийг бэлтгэж хангах үндсэн чиг үүрэг бүхий Зэвсэгт хүчний байр зүй-геодезийн 284 дүгээр анги нь ЗХЖШ-ын Байр зүйн албаны зураг зүйн хөдөлгөөнт анги нэртэйгээр 1982 онд анх үүсэн байгуулагджээ.

Гэрэл зураг—нэг агшин



Цахим шууданд

БАЯНГОЛ ДҮҮРГЭЭС ЦЭРЭГ-СПОРТЫН ДӨЛ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ БАЙГАА СУРАГЧИД ЗОЧИЛЛОО



Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд Баянгол дүүргээс оролцож байгаа сурагчид "Гэрэлт" төвийн хүүхдүүдтэй хамтдаа

хөтөлбөрт хамрагдлаа. Мөн "Дөл" тэмцээнд оролцож байгаа сурагчид "Гэрэлт" төвийн хүүхэд, сурагчдад бэлтгэсэн үзүүлэх тоглолт, жагсаалын бэлтгэлээсээ сонирхуулж тэмцээнд оролцохдоо хэрхэн яаж бэлтгэж байгаа тухайгаа болон цэрэг эх оронч хүүхэд байхын ач холбогдлын талаар ярилцаж өөрсдийн бэлдсэн гарын бэлгээ дурсгаж нэгэн өдрийг өнгөрөөлөө.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



"Соёмбо" сонин



"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)